**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2020 оны 12 дугаар сарын 02- ны өдөр Улаанбаатар хот

Дугаар А/166, А/559, 222

Норматив батлах тухай

Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэг, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт”-ыг нэгдүгээр, “Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г хоёрдугаар, “Ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г гуравдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэг, сургуулийн удирдлагуудад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хүүхдийн хоол, хүнсэнд эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, чанартай хүнсний бүтээгдэхүүнээр илчлэг, шимт бодисын зөвлөмж хэмжээнд хүрсэн хоол хүнс бэлтгэх чиглэлээр арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудлыг хариуцсан нэгж, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д тус тус даалгасугай.

| БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД | ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД | САНГИЙН САЙД |
|---|---|---|
| Л.ЦЭДЭВСҮРЭН | Т.МӨНХСАЙХАН | Ч.ХҮРЭЛБААТАР |

Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд
Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн
А/166, А/559, 222 дугаар хамтарсан тушаалын
нэгдүгээр дүгээр хавсралт

# ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХДИЙН ХОНОГИЙН ХООЛНЫ ИЛЧЛЭГИЙН ХУВААРИЛАЛТ

1. Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногт авбал зохих илчлэгийг дараах хувиар тооцно.

| | | |
|---|---|---|
| 1 | Өдрийн буюу 8 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд | 80 хувь |
| 2 | 24 цагийн үйл ажиллагаатай сувилал, цэцэрлэгийн хүүхэд (хүүхдийн биеийн хөгжлийн онцлогоос хамаарна) | 100 хувь (±10хувь) |
| 3 | Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдардаг хүүхэд | 100 хувь |
| 4 | Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай хөтөлбөр”-т хамрагдаж байгаа хүүхэд | 15 хувь |
| 5 | Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн хоол хөтөлбөр”-т хамрагдаж байгаа хүүхэд (хүүхдийн хөдөлгөөний идэвх, биеийн хөгжлийн онцлогоос хамаарна) | 35 хувь (±10хувь) |

2. Хоногийн хоолны илчлэгийг дараах байдлаар хангана.
   - Өглөөний хоол 20-25 хувь
   - Бага үдийн цай 10-15хувь
   - Үдийн хоол 35 -40хувь
   - Их үдийн цай 10-15хувь
   - Оройн хоол, цай 20хувь
3. Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэх сүү, цагаан идээ 1.5-2.0 хувийн тослогтой байна.
4. Хүүхдийн хоногийн хоолны найрлагад амьтны гаралтай уураг 60-70 хувь байна.
5. Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалаар батлагдсан “Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ” -г үндэслэн тооцсон болно.
6. Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны жишиг хэмжээг цэцэрлэг, сургууль, хүүхэд харах үйлчилгээ, сургуулийн дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөнө.

.....oo0oo.....

Боловсрол, шинжлэх ухааны сайд,
Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны
12 сарын 02 өдрийн А/166/А/359/222 дугаар
хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт-1

# ЦЭЦЭРЛЭГИЙН НАСНЫ ХҮҮХДИЙН ХОНОГИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИШИГ ХЭМЖЭЭ /1-3 НАС/

| Хүнсний бүтээгдэхүүн | Хоногт хэрэглэх хэмжээ (гр) | Үндсэн шимт бодис (гр) | | | Илчлэг (ккал) |
|---|---|---|---|---|---|
| | | Уураг | Тос | Нүүрсус | |
| Малын мах | 60 | 14 | 5 | | 98 |
| Таван цул | 20 | 3 | 1 | | 22 |
| Бусад мах /тахиа, загас, гахай/ | 15 | 4 | 1 | | 29 |
| Сүү (үнээний сүү, 3.2%) | 70 | 2 | 2 | 3 | 45 |
| Цагаан идээ (тараг, 2.5%) | 80 | 2 | 2 | 3 | 41 |
| Гурил | 45 | 4 | | 31 | 146 |
| Гурилан бүтээгдэхүүн | 70 | 6 | 2 | 36 | 186 |
| Төрөл бүрийн будаа | 30 | 2 | | 24 | 106 |
| Төмс | 50 | 1 | | 8 | 38 |
| Хүнсний ногоо | 120 | 2 | | 8 | 40 |
| Буурцагт ургамал (вандуй, шош) | 20 | 1 | | 4 | 21 |
| Жимс, жимсгэнэ | 120 | | | 16 | 68 |
| Ургамлын тос | 10 | | 10 | | 90 |
| Цөцгийн тос, 75% тослог | 6 | | 5 | | 41 |
| Сахар, чихрийн зүйл | 12 | | | 12 | 48 |
| НИЙТ | | 42 | 30 | 147 | 1020 |
| Үндсэн шимт бодисын илчлэг | | 167 | 266 | 586 | |
| Үндсэн шимт бодисын илчлэгийн хувь | | 16% | 26% | 57% | |

Тайлбар:
1. Хоногт авбал зохих илчлэгийн **100 хувийг** авахаар тооцсон болно.
2. Илчлэг, шимт бодисын хэрэгцээг тооцоход махыг үхрийн гуяны мах, таван цулыг хонины /уушги, зүрх, гүзээ, элэг, бөөр/, бусад махыг тахианы махаар, гурилыг улаан буудайн 1 дүгээр гурилаар, гурилан бүтээгдэхүүнийг Та-Чи ХХК-ийн мишээл талх, төрөл бүрийн будааг цагаан будаагаар, хүнсний ногоог монгол луувангаар, жимсийг улаан алимаар, буурцагт ургамлыг лаазалсан хүрэн шошоор төлөөлүүлэн авсан болно.
3. Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний цэвэр жин бөгөөд хүнсний бүтээгдэхүүний захиалга, ханган нийлүүлэлт хийхдээ хорогдлыг нэмж тооцож, төлөвлөнө.

Боловсрол, шинжлэх ухааны сайд,
Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны
12 сарын 02 өдрийн А/166/А/559/222 дугаар
хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт-2

# ЦЭЦЭРЛЭГИЙН НАСНЫ ХҮҮХДИЙН ХОНОГИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИШИГ ХЭМЖЭЭ /4-6 НАС/

| Хүнсний бүтээгдэхүүн | Хоногт хэрэглэх хэмжээ (гр) | Үндсэн шимт бодис (гр) | | | Илчлэг (ккал) |
|---|---|---|---|---|---|
| | | Уураг | Тос | Нүүрсус | |
| Малын мах | 80 | 18 | 6 | | 131 |
| Таван цул | 25 | 4 | 1 | | 28 |
| Бусад мах /тахиа, загас, гахай/ | 20 | 6 | 2 | | 38 |
| Сүү (үнээний сүү, 3.2%) | 120 | 4 | 4 | 6 | 73 |
| Цагаан идээ (тараг, 2.5%) | 130 | 4 | 3 | 6 | 67 |
| Гурил | 55 | 5 | 1 | 38 | 179 |
| Гурилан бүтээгдэхүүн | 100 | 8 | 3 | 51 | 266 |
| Төрөл бүрийн будаа | 55 | 3 | 1 | 44 | 195 |
| Төмс | 65 | 1 | | 11 | 50 |
| Хүнсний ногоо | 160 | 2 | | 11 | 54 |
| Буурцагт ургамал (вандуй, шош) | 30 | 2 | | 6 | 31 |
| Жимс, жимсгэнэ | 160 | | | 22 | 91 |
| Ургамлын тос | 10 | | 10 | | 90 |
| Цөцгийн тос, 75% тослог | 8 | | 6 | | 55 |
| Сахар, чихрийн зүйл | 14 | | | 14 | 56 |
| НИЙТ | | 58 | 38 | 208 | 1402 |
| Үндсэн шимт бодисын илчлэг | | 233 | 338 | 832 | |
| Үндсэн шимт бодисын илчлэгийн хувь | | 17% | 24% | 59% | |

Тайлбар: 1. Хоногт авбал зохих илчлэгийн **100 хувийг** авахаар тооцсон болно.
2. Илчлэг, шимт бодисын хэрэгцээг тооцоход махыг үхрийн гуяны мах, таван цулыг хонины /уушги, зүрх, гүзээ, элэг, бөөр/, бусад махыг тахианы махаар, гурилыг улаан буудайн 1 дүгээр гурилаар, гурилан бүтээгдэхүүнийг Та-Чи ХХК-ийн мишээл талх, төрөл бүрийн будааг цагаан будаагаар, хүнсний ногоог монгол луувангаар, жимсийг улаан алимаар, буурцагт ургамлыг лаазалсан хүрэн шошоор төлөөлүүлэн авсан болно.
3. Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний цэвэр жин бөгөөд хүнсний бүтээгдэхүүний захиалга, ханган нийлүүлэлт хийхдээ хорогдлыг нэмж тооцож, төлөвлөнө.

Боловсрол, шинжлэх ухааны сайд,
Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны
12 сарын 02 өдрийн А/166/А/559/222 дугаар
хамтарсан тушаалын гуравдугаар хавсралт-1

# ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХДИЙН ХОНОГИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИШИГ ХЭМЖЭЭ /7-10 НАС/

| Хүнсний бүтээгдэхүүн | Хоногт хэрэглэх хэмжээ (гр) | Үндсэн шимт бодис (гр) | | | Илчлэг (ккал) |
|---|---|---|---|---|---|
| | | Уураг | Тос | Нүүрсус | |
| Малын мах | 83 | 19 | 7 | | 136 |
| Таван цул | 30 | 5 | 1 | | 33 |
| Бусад мах /тахиа, загас, гахай/ | 25 | 7 | 2 | | 48 |
| Сүү (үнээний сүү, 3.2%) | 150 | 5 | 5 | 7 | 96 |
| Цагаан идээ (тараг, 2.5%) | 160 | 5 | 4 | 7 | 83 |
| Гурил | 70 | 7 | 1 | 49 | 228 |
| Гурилан бүтээгдэхүүн | 120 | 9 | 4 | 61 | 319 |
| Төрөл бүрийн будаа | 70 | 4 | 1 | 56 | 248 |
| Төмс | 75 | 2 | | 12 | 58 |
| Хүнсний ногоо | 210 | 3 | | 14 | 71 |
| Буурцагт ургамал (вандуй, шош) | 35 | 2 | | 7 | 36 |
| Жимс, жимсгэнэ | 200 | 1 | | 27 | 114 |
| Ургамлын тос | 15 | | 15 | | 135 |
| Цөцгийн тос, 75% тослог | 10 | | 8 | | 68 |
| Сахар, чихрийн зүйл | 16 | | | 16 | 64 |
| НИЙТ | | 68 | 48 | 275 | 1735 |
| Үндсэн шимт бодисын илчлэг | | 273 | 434 | 1027 | |
| Үндсэн шимт бодисын илчлэгийн хувь | | 16% | 25% | 59% | |

Тайлбар:
1. Хоногт авбал зохих илчлэгийн **100 хувийг** авахаар тооцсон болно.
2. Илчлэг, шимт бодисын хэрэгцээг тооцоход махыг үхрийн гуяны мах, таван цулыг хонины /уушги, зүрх, гүзээ, элэг, бөөр/, бусад махыг тахианы махаар, гурилыг улаан буудайн 1 дүгээр гурилаар, гурилан бүтээгдэхүүнийг Та-Чи ХХК-ийн мишээл талх, төрөл бүрийн будааг цагаан будаагаар, хүнсний ногоог монгол луувангаар, жимсийг улаан алимаар, буурцагт ургамлыг лаазалсан хүрэн шошоор төлөөлүүлэн авсан болно.
3. Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний цэвэр жин бөгөөд хүнсний бүтээгдэхүүний захиалга, ханган нийлүүлэлт хийхдээ хорогдлыг нэмж тооцож, төлөвлөнө.

Боловсрол, шинжлэх ухааны сайд,
Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны
12 сарын 02 өдрийн А/166/А/559/222 дугаар
хамтарсан тушаалын гуравдугаар хавсралт-2

# ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХДИЙН ХОНОГИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИШИГ ХЭМЖЭЭ /11-14 НАС/

| Хүнсний бүтээгдэхүүн | Хоногт хэрэглэх хэмжээ (гр) | Үндсэн шимт бодис (гр) | | | Илчлэг (ккал) |
|---|---|---|---|---|---|
| | | Уураг | Тос | Нүүрсус | |
| Малын мах | 100 | 23 | 8 | | 164 |
| Таван цул | 41 | 7 | 2 | | 45 |
| Бусад мах /тахиа, загас, гахай/ | 25 | 7 | 2 | | 48 |
| Сүү (үнээний сүү, 3.2%) | 200 | 7 | 7 | 10 | 128 |
| Цагаан идээ (тараг, 2.5%) | 180 | 5 | 5 | 8 | 93 |
| Гурил | 95 | 9 | 1 | 66 | 309 |
| Гурилан бүтээгдэхүүн | 200 | 16 | 7 | 102 | 532 |
| Төрөл бүрийн будаа | 100 | 6 | 1 | 80 | 354 |
| Төмс | 80 | 2 | | 13 | 61 |
| Хүнсний ногоо | 250 | 3 | | 17 | 84 |
| Буурцагт ургамал (вандуй, шош) | 40 | 2 | | 8 | 41 |
| Жимс, жимсгэнэ | 250 | 1 | | 34 | 142 |
| Ургамлын тос | 20 | | 20 | | 180 |
| Цөцгийн тос, 75% тослог | 12 | | 9 | | 82 |
| Сахар, чихрийн зүйл | 18 | | | 18 | 72 |
| **НИЙТ** | | 88 | 62 | 356 | 2335 |
| Үндсэн шимт бодисын илчлэг | | 352 | 560 | 1423 | |
| Үндсэн шимт бодисын илчлэгийн хувь | | 15% | 24% | 61% | |

Тайлбар:
1. Хоногт авбал зохих илчлэгийн **100 хувийг** авахаар тооцсон болно.
2. Илчлэг, шимт бодисын хэрэгцээг тооцоход махыг үхрийн гуяны мах, таван цулыг хонины /уушги, зүрх, гүзээ, элэг, бөөр/, бусад махыг тахианы махаар, гурилыг улаан буудайн 1 дүгээр гурилаар, гурилан бүтээгдэхүүнийг Та-Чи ХХК-ийн мишээл талх, төрөл бүрийн будааг цагаан будаагаар, хүнсний ногоог монгол луувангаар, жимсийг улаан алимаар, буурцагт ургамлыг лаазалсан хүрэн шошоор төлөөлүүлэн авсан болно.
3. Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний цэвэр жин бөгөөд хүнсний бүтээгдэхүүний захиалга, ханган нийлүүлэлт хийхдээ хорогдлыг нэмж тооцож, төлөвлөнө.

Боловсрол, шинжлэх ухааны сайд,
Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны
12 сарын 02 өдрийн А/166 / А/459 / 222 дугаар
хамтарсан тушаалын гуравдугаар хавсралт-3

# ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН НАСНЫ ХҮҮХДИЙН ХОНОГИЙН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖИШИГ ХЭМЖЭЭ /15-18 НАС/

| Хүнсний бүтээгдэхүүн | Хоногт хэрэглэх хэмжээ (гр) | Үндсэн шимт бодис (гр) | | | Илчлэг (ккал) |
|---|---|---|---|---|---|
| | | Уураг | Тос | Нүүрсус | |
| Малын мах | 115 | 26 | 9 | | 188 |
| Таван цул | 59 | 10 | 3 | | 65 |
| Бусад мах /тахиа, загас, гахай/ | 30 | 9 | 3 | | 57 |
| Сүү (үнээний сүү, 3.2%) | 200 | 7 | 7 | 10 | 128 |
| Цагаан идээ (тараг, 2.5%) | 200 | 6 | 5 | 9 | 103 |
| Гурил | 100 | 9 | 1 | 70 | 325 |
| Гурилан бүтээгдэхүүн | 200 | 16 | 7 | 102 | 532 |
| Төрөл бүрийн будаа | 110 | 7 | 1 | 88 | 389 |
| Төмс | 90 | 2 | | 15 | 69 |
| Хүнсний ногоо | 270 | 4 | | 19 | 91 |
| Буурцагт ургамал (вандуй, шош) | 45 | 3 | | 8 | 46 |
| Жимс, жимсгэнэ | 270 | 1 | | 37 | 154 |
| Ургамлын тос | 20 | | 20 | | 180 |
| Цөцгийн тос, 75% тослог | 12 | | 9 | | 82 |
| Сахар, чихрийн зүйл | 20 | | | 20 | 80 |
| НИЙТ | | 98 | 65 | 377 | |
| Үндсэн шимт бодисын илчлэг | | 394 | 589 | 1507 | 2490 |
| Үндсэн шимт бодисын илчлэгийн хувь | | 16% | 24% | 61% | |

Тайлбар: 1. Хоногт авбал зохих илчлэгийн **100 хувийг** авахаар тооцсон болно.
2. Илчлэг, шимт бодисын хэрэгцээг тооцоход махыг үхрийн гуяны мах, таван цулыг хонины /уушги, зүрх, гүзээ, элэг, бөөр/, бусад махыг тахианы махаар, гурилыг улаан буудайн 1 дүгээр гурилаар, гурилан бүтээгдэхүүнийг Та-Чи ХХК-ийн мишээл талх, төрөл бүрийн будааг цагаан будаагаар, хүнсний ногоог монгол луувангаар, жимсийг улаан алимаар, буурцагт ургамлыг лаазалсан хүрэн шошоор төлөөлүүлэн авсан болно.
3. Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ нь тухайн бүтээгдэхүүний цэвэр жин бөгөөд хүнсний бүтээгдэхүүний захиалга, ханган нийлүүлэлт хийхдээ хорогдлыг нэмж тооцож, төлөвлөнө.

.....oo0oo.....